



НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 24.1, Амаржих газрын дүрмийн 2.6.1, хөдөлмөрийн дотоод журмын 6.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэнийг ажилд авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажилд авах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Уг журмыг мөрдлөг болгож ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Амаржих газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/06 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.БАТБОЛД

Нийслэлийн Амгалан амаржих газрын даргын  
2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ИРГЭНИЙГ АЖИЛД АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Амаржих газрын дарга, ерөнхий эмч

Нарийн бичгийн дарга: Хүний нөөцийн менежер

Гишүүд:

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Байгууллагын бодлого төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга


Ахлах нягтлан бодогч

Чанарын албаны дарга

Сувилахуйн албаны дарга

Хангамж үйлчилгээ, аж ахуйн албаны дарга

Нийслэлийн Амгалан амаржих газрын даргын  
2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## АМАРЖИХ ГАЗАРТ ШИНЭЭР АЖИЛТАН АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нийслэлийн Амгалан амаржих газарт хүний нөөцийн хэрэгцээг мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвартай эмч, ажилтнаар хангах, ажил горилогч иргэдийг сонгон шалгаруулах зарчмаар ажилд авах болон түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сонгон шалгаруулалт гэж тухайн ажлын байранд мэргэжил, боловсрол, ур чадвар, эрүүл мэндийн хувьд тохирох иргэдээс сонгох үйл ажиллагааг хэлнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтад хамрагдах иргэд, тавигдах шаардлага

- 2.1. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр болон түүнээс дээш боловсролтой төгссөн их эмч, дипломын болон түүнээс дээш боловсролтой төгссөн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд,
- 2.2. Төрөлжсөн болон нарийн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд,
- 2.3. Сул орон тоо болон шинээр бий болсон ажлын байранд бүртгүүлсэн болон бүртгэлтэй иргэд,
- 2.4. Сонгон шалгаруулалтад хамрагдах иргэдэд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд: Боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүний их эмч, эм зүйч, дипломын болон түүнээс дээш зэрэгтэй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэй, ажлын туршлагатай, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх 5 жилийн зөвшөөрөлтэй байх,
- 2.5. Сонгон шалгаруулалтад хамрагдах иргэдэд дараах тусгай шаардлага тавигдана. Үүнд: Гадаад хэлний анхан, дунд түвшинээс доошгүй мэдлэгтэй, компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн ашиглаж чадах, интернетийн орчин, дотоод сүлжээнд ажиллах, судалгааны арга зүйд суралцсан, багаар ажиллах чадвартай, яриа харилцаа, хувийн соёл зохион байгуулалт сайтай, хууль эрх зүйн тодорхой түвшний мэдлэгтэй байх,
- 2.6. Тусгай шаардлага: Төрийн албан хаагч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журам, авилгын болон бусад холбогдох хуулийг чанд сахиж, авилгаас ангид ажиллах чадвар төлөвшсөн. Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах.

### Гурав. Сонгон шалгаруулалт

- 3.1 Амаржих газарт сул орон тоо болон шинээр бий болсон ажлын байрны захиалгыг хүний нөөцийн менежер нэгтгэн сонгон шалгаруулалтыг зарлана.
- 3.2 Хүний нөөцийн менежер нь нээлттэй ажлын байрыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн хэрэгсэл, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын цахим хуудас, дүүргүүдийн хөдөлмөрийн хэлтсээр зарлаж, анкетаар бүртгэнэ.
- 3.3 Сонгон шалгаруулалтанд оролцох иргэд дараах материалыг бүрдүүлнэ.  
Үүнд:
  - ✓ Төрийн албан хаагчийн анкет /Маягт №1/
  - ✓ Ажилд орохыг хүссэн өргөдөл
  - ✓ Иргэний үнэмлэх /хуулбар нотариатаар баталгаажуулсан/
  - ✓ Боловсролын үнэмлэх, диплом /хуулбар нотариатаар баталгаажуулсан
  - ✓ Эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрлийн гэрчилгээ /хуулбар нотариатаар баталгаажуулсан/
  - ✓ Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4х6 зураг
  - ✓ Мэргэшлийн зэрэг, дэвийн үнэмлэх /хуулбарыг нотариатаар баталгаажуулсан/
- 3.4 Сул орон тооны ажлын байрны тодорхойлолтонд заагдсан шаардлагыг хангаагүй, мэргэжлийн үнэмлэх дипломгүй, баримт бичиг дутуу иргэдийн материалыг хүлээн авахгүй.
- 3.5 Сонгон шалгаруулалтыг анкеттай танилцах, ярилцлага хийх, сорилын шалгалт авах, ур чадварын сорил авах зэрэг хэлбэрээр зохион байгуулна.
- 3.6 Бүртгүүлсэн иргэдийн материалыг судалж, ажлын байрны шаардлагыг хангах хүмүүсийг сонгоно.
- 3.7 Ерөнхий мэргэжлийн сорилыг сонгон шалгаруулах ажлын хэсэг холбогдох албаны дарга нартай хамтран боловсруулж, мэргэжил, ёс зүй, онолын ерөнхий мэдлэгийн сорилын шалгалт авна.
- 3.8 Сорилд тэнцсэн иргэдийг ярилцлаганд оруулж, үнэлгээ өгнө.
- 3.9 Сонгон шалгаруулалтыг шалгалт, ярилцлагын нийлбэр оноогоор дүгнэх бөгөөд шалгаруулалтад хамгийн өндөр оноо авч тэнцсэн ажил горилогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулна.
- 3.10 Сонгогдсон ажилтанд ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журам, холбогдох бусад журмуудыг танилцуулж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах аялалыг зохион байгуулна.
- 3.11 Сонгогдсон иргэн нэмэлтээр дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
  - ✓ Оршин суугаа нутаг дэвсгэрийн тодорхойлолт
  - ✓ Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4х6 зураг 2-3%
  - ✓ Эрүүл мэндийн шинжилгээний дэвтэр
  - ✓ Хөдөлмөрийн дэвтэр /1995 оноос өмнө ажиллаж байсан бол/
  - ✓ Нийгмийн даатгалын дэвтэр /хуучин, шинэ/
  - ✓ Эрүүл мэндийн даатгалын дэвтэр

- ✓ Урьд нь хөдөлмөр эрхэлж байсан бол хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгосон тушаал
- ✓ Бичиг хэргийн хавтас 20 хуудастай хавтас -1ширхэг
- ✓ Сонгон шалгаруулалтад оролцох иргэн өдрийн цагаар их, дээд, дунд сургууль болон бусад сургалтанд хамрагдаж байгаа цаашид үргэлжлүүлэн суралцах бол сонгон шалгаруулалтанд оролцохгүй

#### Дөрөв. Дагалдан болон туршилтын хугацаа

- 4.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн ажилтныг ажилд авахдаа эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах, дасан зохицох, тухайн ажлын байранд тавигдах шаардлагад тэнцэх эсэхийг тодорхойлох зорилгоор ажлын 10 хоног (хуанлийн 14 хоног)-ийн хугацаагаар цалингүй дагалдуулан ажиллуулна.
- 4.2. Дагалдан ажиллах хугацаа дуусмагц тухайн ажлын байрны тавигдах шаардлагыг хангахаар бол тухайн албаны дарга, тасгийн эрхлэгч, хэсгийн ахлагчийн саналыг үндэслэн хөдөлмөрийн гэрээ байгуулан туршилтын хугацаагаар ажиллуулна.
- 4.3. Туршилтын хугацаа 3 сар байна. Туршилтын хугацаа дуусахад ажилтан ажилласан хугацааны тайлан батлагдсан загварын дагуу ирүүлнэ. Туршилтын хугацаанд сар бүр ажлаа дүгнүүлнэ. Үр дүнгийн урамшуулал олгохгүй.
- 4.4. Тасгийн эрхлэгч, хэсгийн ахлагчийн санал, тайланг үндэслэн туршилтын хугацаа дуусмагц цаашид хугацаагүй ажиллах гэрээг амаржих газрын дарга хийнэ.

#### Тав. Хөдөлмөрийн гэрээ байгуулах

- 5.1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн 24.1 дэх заалтын дагуу бичгээр байгуулна.
- 5.2. Хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа ажилтан болон байгууллагын эрх ашиг хүлээх үүргийг уншуулж судлуулан 2 хувь үйлдэж, хоёр талын төлөөлөл гарын үсэг зурж баталгаажуулна.

#### Зургаа. Хүлээх үүрэг хариуцлага.

- 6.1. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүн, холбогдох мэргэжилтэн нь шалгалтын материалын нууцыг задруулах, оролцогчдод мэдээлэл өгөх, тэднээс бэлэг, шан харамж авах, энэхүү журмын заалтуудыг илт зөрчсөн үйлдэл хийсэн нь нотлогдвол байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.2. Энэхүү журмын хэрэгжилтэнд хүний нөөцийн алба хяналт тавина.

## Долоо. Ажлын тайлан ирүүлэх, хамгаалах

.....овогтой.....нь  
хөдөлмөрийн гэрээ байгуулсанаас хойш 3 сарын дараа ..... 20.... оны ....  
сарын.....-ны өдөр ажилласан хугацааны тайлан хамгаална.

Тайланд: Дараах зүйлийг тусгана.

1. Өдөр бүрийн хийсэн ажлын тэмдэглэл
2. Идэвх, санаачлагаа дайчлан эмчилгээ, оношлогоо, сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээнд санаачлан хийсэн зүйлс
3. Ажлын хариуцлага /ажлын цаг ашиглалт, хурал, сургалтын ирц/
4. Ёс зүй, харилцаа хандлагын зөрчил гаргаагүй байх
5. Байгууллагаас зохиогдсон олон нийтийн ажилд оролцсон байдал
6. Тасгийн эрхлэгчийн санал
7. Туршилтын хугацаанд байгуулсан хөдөлмөрийн гэрээ